



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 4/11

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, ТҮЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн №14 дүгээр тогтоол, Гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1.1 дахь заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалт болон тус компанийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 23/63 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Голомт капитал УЦК” ХХК-ийн брокер Э.Намуунаа /УЗ 00232401/-д үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
- Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
- Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ



1523020003